



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.03.15 № 656
танай _____-ны № _____-т

УС СУВГИЙН УДИРДАХ
ГАЗАР ОНӨААТҮГ-ЫН ДАРГА
Т.ВАНДАНДОРЖ ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага нь бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд “Нийслэлийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжих 22 ажлын хэрэгжилт 81.5%, “Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2023 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-тэй холбоотойгоор хэрэгжих 14 ажлын хэрэгжилт 84.1 %, “Нийслэлийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөө”-тэй уялдсан 14 ажлыг 91.4%, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 115 ажил төлөвлөснөөс хэрэгжилт 96.4% дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамруулаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2024/26/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	Санхүү нийцлийн аудитын хэлтсийн дарга Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
	Аудитын менежер: Д.Отгонбаяр Утас: 315558 Цахим хаяг: otgonbayard@audit.gov.mn
	Ахлах аудитор: Н.Бадамхатан Утас: 325093 Цахим хаяг: badamkhatann@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	1
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	12
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	13
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	22

Товчилсон үгийн жагсаалт

НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЗГ	Монгол улсын Засгийн газар
НЗД	Нийслэлийн Засаг дарга
НИТХ	Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ЗГ	Засгийн газар
МУШС	Монгол улсын Шадар сайд
БОНХЯ	Байгаль орчин, Нийгмийн хамгааллын яам
НӨХГ	Нийслэлийн Өмчийн харилцааны газар
ХСУХАТАҮЗЗ	Хот суурины ус хангамж, ариутгах, татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл
УБЦТС	Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
БХУСАТ	Багахангай Ус суваг ашиглалтын товчоо
НҮА	Нийтлэг үйлчилгээний алба
УЦБА	Урьдчилан цэвэрлэх байгууламжийн алба
ЦБА	Цэвэрлэх байгууламжийн алба
МТАН	Мэдээлэл технологи автоматжуулалтын алба
УХА	Ус хангамжийн алба
ЗУХА	Зөөврийн ус хангамжийн алба
ЖМС	Жижиг мөнгөн сан
ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
БХӨТ	Богино хугацаат өр төлбөр
УХӨТ	Урт хугацаат өр төлбөр
ХХХМС	Хэрэглэгчидтэй харилцах харилцааны менежментийн систем

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд "Нийслэлийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн хүрээнд хэрэгжих 22 ажлын хэрэгжилт 81.5%, "Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2023 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-тэй холбоотойгоор хэрэгжих 14 ажлын хэрэгжилт 84.1 %, "Нийслэлийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөө"-тэй уялдсан 14 ажлыг 91.4%, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 115 ажил төлөвлөснөөс хэрэгжилт 96.4% дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамруулаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө	44,714,477,613.05	59,363,021,102.33
1.1.2	Дансны авлага	13,010,039,527.77	11,186,108,377.96
1.1.3	Татвар, НДШ □ ийн авлага	1,257,850,351.35	1,499,302,175.93
1.1.4	Бусад авлага	23,129,581.52	6,806,092.36
1.1.6	Бараа материал	9,204,602,231.81	15,061,291,404.28
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	316,962,698.55	294,162,542.82
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	68,527,062,004	87,410,691,695.68
1.2.1	Үндсэн хөрөнгө	311,444,826,712.08	290,096,302,892.59
1.2.2	Биет бус хөрөнгө	112,963,866,433.91	112,476,851,903.31
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	459,007,531.81	13,975,500.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	424,867,700,677.80	402,587,130,295.90
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	493,394,762,681.85	489,997,821,991.58
2.1.1.1	Дансны өглөг	876,383,918.15	749,405,699.29
2.1.1.3	Татварын өр	1,709,907,425.68	39,349,020.65
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	742,081,483.27	848,200,002.18
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	25,686,345.65	140,577,282.45
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	3,354,059,172.75	1,777,532,004.57
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	578,345,584.03	109,349,788.01
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	578,345,584.03	109,349,788.01
2.2	Өр төлбөрийн нийт дүн	3,932,404,756.78	1,886,881,792.58
2.3	Өмч:	874,877,566.30	874,877,566.30
2.3.1	- төрийн	874,877,566.30	874,877,566.30
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	111,920,778,280.94	111,919,323,994.14
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	450,591,592,284.17	458,570,138,667.30
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(73,924,890,206.34)	(83,253,400,028.74)
2.3.11	Эздийн өмчийн дүн	489,462,357,925.07	488,110,940,199.00
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	493,394,762,681.85	489,997,821,991.58

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	100,978,475,328.36	106,337,564,678.33
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	92,671,194,695.52	108,981,088,412.65
3	Нийт ашиг (алдагдал)	8,307,280,632.84	(2,643,523,734.32)
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	296,196,872.79	1,405,134,402.83
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого		
9	Борлуулалт, маркетингийн зардал	2,452,491,098.21	3,111,324,144.08
10	Ерөнхий ба удирдлагын зардал	3,165,205,844.68	4,066,020,275.32
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	7,478,653.88	(430,252.07)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	909,499,503.73	969,124,240.70
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	3,902,758,720.35	(7,447,039,762.26)
19	Орлогын татварын зардал	2,022,089,985.00	184,185,803.00
20	Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	1,880,668,735.35	(7,631,225,565.26)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1,880,668,735.35	(7,631,225,565.26)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	1,880,668,735.35	(7,631,225,565.26)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	874,877,566.30	111,938,139,567.97	435,536,008,850.18	(75,129,637,779.78)	473,219,388,204.67
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				16,257,582.49	16,257,582.49
Залруулсан үлдэгдэл	874,877,566.30	111,938,139,567.97	435,536,008,850.18	(75,113,380,197.29)	473,235,645,787.16
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				1,880,668,735.35	1,880,668,735.35
Өмчид гарсан өөрчлөлт		(17,361,287.03)	15,055,583,433.99	(692,178,744.40)	14,346,043,402.56
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	874,877,566.30	111,920,778,280.94	450,591,592,284.17	(73,924,890,206.34)	489,462,357,925.07
2023 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл	874,877,566.30	111,920,778,280.94	450,591,592,284.17	(73,924,890,206.34)	473,219,388,204.67
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
Залруулсан үлдэгдэл	874,877,566.30	111,920,778,280.94	450,591,592,284.17	(73,924,890,206.34)	489,462,357,925.07
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(7,631,225,565.26)	(7,631,225,565.26)
Өмчид гарсан өөрчлөлт			7,978,546,383.13	(1,697,284,257.14)	6,281,262,125.99
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(1,454,286.80)			(1,454,286.80)
2023 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	874,877,566.30	111,919,323,994.14	458,570,138,667.30	(83,253,400,028.74)	488,110,940,199.00

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны дүн	12-р сарын 31
1			
1.1	Мөнгөн орлогын дүн	122,908,911,020.04	123,089,538,595.35
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	120,912,732,788.62	120,364,579,453.82
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	6,648,750.00	1,495,800.00
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	139,023,500.00	
1.1.6	Бусад мөнгөн орлого	1,850,505,981.42	2,723,463,341.53
1.2	Мөнгөн зарлагын дүн	82,415,408,603.66	101,162,250,538.32
1.2.1	Ажиллагчдад төлсөн	32,591,254,115.17	40,159,350,269.85
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	9,853,411,656.81	12,155,901,321.95
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	6,447,138,201.50	4,866,698,603.87
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	13,423,090,631.96	18,498,379,016.14
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	3,430,947,235.75	3,903,515,711.91
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	12,197,724,491.67	14,491,779,815.49
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	46,192,974.00	26,287,532.39
1.2.9	Бусад мөнгөн зарлага	4,425,649,296.80	7,060,338,266.72
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	40,493,502,416.38	21,927,288,057.03
2.1.8			
2.2	Мөнгөн зарлагын дүн	9,353,004,409.08	7,278,314,315.68
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	9,087,600,963.08	7,117,557,765.68
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	265,403,446.00	160,756,550.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.2.6	Бусад		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(9,353,004,409.08)	(7,278,314,315.68)
3			
3.1	Мөнгөн орлогын дүн	7,478,653.88	1,486,113.80
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.1.4	Бусад	7,478,653.88	1,486,113.80
3.2	Мөнгөн зарлагын дүн	-	1,916,365.87
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг		

3.2.5	Бусад		1,916,365.87
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	7,478,653.88	(430,252.07)
4			
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	31,147,976,661.18	14,648,543,489.28
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	13,566,500,951.87	44,714,477,613.05
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	44,714,477,613.05	59,363,021,102.33

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Нийт орлогын дүн	100,978,475.3	106,337,564.7	5,359,089.4	105.3%
1.1	Цэвэр усны орлого	54,814,462.2	57,580,121.5	2,765,659.3	105.0%
1.2	Бохир ус татан зайлуулсан орлого	43,157,909.0	45,530,393.0	2,372,484.0	105.5%
1.3	Бусад орлого	3,006,104.1	3,227,050.2	220,946.1	107.3%
2	Нийт зардал	120,775,905.3	116,158,432.8	(4,617,472.5)	96.2%
2.1	Үндсэн ба нэмэгдэл цалин	46,761,555.5	47,834,946.0	1,073,390.5	102.3%
2.2	Ажил олгогчоос эмнэлгийн хуудсаар олгосон	104,530.0	140,456.6	35,926.6	134.4%
2.3	НДШ, ЭМД	6,259,106.2	6,442,861.6	183,755.4	102.9%
2.4	Хоол, унаа	2,097,579.3	1,980,267.0	(117,312.3)	94.4%
2.5	Сургалт	197,549.0	110,705.4	(86,843.6)	56.0%
2.6	Тэтгэмж болон нийгмийн арга хэмжээ	292,655.0	275,106.0	(17,549.0)	94.0%
2.7	Шагнал	22,810.0	37,966.2	15,156.2	166.4%
2.8	Хлор, манганы сульфат, бодис, давс	2,894,524.9	1,896,709.6	(997,815.3)	65.5%
2.9	Сэлбэг, багаж хэрэгсэл	3,228,264.4	2,566,671.2	(661,593.2)	79.5%
2.10	Хангамжийн зардал	152,650.7	134,603.5	(18,047.2)	88.2%
2.11	Түлээ, нүүрс	47,428.0	42,192.0	(5,236.0)	89.0%
2.12	Шатахуун, тосолгоо	3,912,295.4	3,201,711.9	(710,583.5)	81.8%
2.13	Цахилгаан	16,346,311.9	15,928,589.1	(417,722.8)	97.4%
2.14	Дулаан, СӨХ	479,540.0	377,237.1	(102,302.9)	78.7%
2.15	Ус	34,736.4	35,570.4	834.0	102.4%
2.16	Харуул, хамгаалалт	335,090.9	282,671.6	(52,419.3)	84.4%
2.17	Урсгал засвар, аваар, аваарын нөөц сан, тохижилт	1,880,569.4	1,246,159.4	(634,410.0)	66.3%
2.18	Лагийн зардал	120,563.6	83,124.8	(37,438.8)	68.9%
2.19	Бичиг хэрэг	89,544.0	66,652.3	(22,891.7)	74.4%
2.20	Холбоо шуудан холбоо, хэвлэл захиалга	281,626.4	241,783.4	(39,843.0)	85.9%
2.21	Томилолт	54,500.0	54,378.5	(121.5)	99.8%
2.22	Зар сурталчилгаа, олон нийтийн зардал	127,918.0	127,688.7	(229.3)	99.8%
2.23	Гаднын үйлчилгээ	87,036.5	74,041.4	(12,995.1)	85.1%
2.24	Банкны үйлчилгээ	7,148.4	5,060.2	(2,088.2)	70.8%
2.25	Хөдөлмөр хамгаалал	1,400,692.3	1,205,404.3	(195,288.0)	86.1%
2.26	Лабораторийн зардал	283,937.0	119,205.9	(164,731.1)	42.0%
2.27	Төслийн зардал	578,813.1	180,391.8	(398,421.3)	31.2%
2.28	УЗ-ын зардал	54,822.6	47,614.6	(7,208.0)	86.9%
2.29	Найдваргүй авлагын зардал	69,928.4	-	(69,928.4)	0.0%
2.30	Татвар, хураамж	1,022,829.3	985,220.2	(37,609.1)	96.3%
2.31	Даатгал	110,204.0	67,139.4	(43,064.6)	60.9%

2.32	Зээлийн хүү	-	-	-	
2.33	Элэгдэл	31,439,144.7	30,366,302.7	(1,072,842.0)	96.6%
3	Үйл ажиллагааны алдагдал	(19,797,430.0)	(9,820,868.1)	9,976,561.9	49.6%
4	Үйл ажиллагааны орлогын нэг төгрөгт ногдох зардал	1.20	1.09	(0.1)	91.3%
5	Үйл ажиллагааны бус орлого	2,191,355.4	3,311,203.9	1,119,848.5	151.1%
6	Үйл ажиллагааны бус зардал	973,595.5	937,375.5	(36,220.0)	96.3%
7	Нийт орлого	103,169,830.7	109,648,768.6	6,478,937.9	106.3%
8	Нийт зардал	121,749,500.8	117,095,808.3	(4,653,692.5)	96.2%
9	ОНТНЗ	1.18	1.07	(0.1)	90.5%
10	Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдал	(18,579,670.1)	(7,447,039.7)	11,132,630.4	40.1%
11	Орлогын татварын зардал		184,185.8	184,185.8	
12	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	(18,579,670.1)	(7,631,225.6)	10,948,444.5	41.1%
13	Авлага	9,107,027.7	11,186,108.4	2,079,080.7	122.8%
14	Нийт өр төлбөр	2,359,442.9	1,886,881.8	(472,561.1)	80.0%
15	Хөрөнгө оруулалт	10,416,370.0	7,278,314.3	(3,138,055.7)	69.9%
16	Орон тоо	1,883.0	1,805.0	(78.0)	95.9%

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг “Нийслэлийн хүн ам, албан байгууллагуудад стандартын шаардлага хангасан цэвэр усаар тасралтгүй хангах, бохирдсон усыг зохих стандартын дагуу цэвэрлэж зайлуулах, хэрэглэгчдийн усны алдагдлыг бууруулах, усны бохирдолтын хэмжээнд хяналт тавих, усны эх үүсвэр, нөөцийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах, цэвэр бохир усанд лабораторийн шинжилгээ хийж хяналт тавих, эзэмшлийн инженерийн шугам, сүлжээ, тоноглолд технологийн шинэчлэлт хийх” гэж тодорхойлсон байна.

Тайлант онд Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ нь “Чадварлаг хүний нөөц, байгальд ээлтэй дэвшилтэт технологиор ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэж, хөгжилд тэмүүлсэн манлайлагч байгууллага болно” гэх эрхэм зорилгыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд ОНӨААТҮГ статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ нь үйл ажиллагаандаа:

- Монгол улсын Усны тухай хууль;
- Зөвшөөрлийн тухай хууль;
- Зөрчлийн тухай хууль;
- Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль;
- Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль;
- МУЗГ-ын 2009 оны 143 дугаар тогтоол “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”;
- МУЗГ-ын 311 дүгээр тогтоол “Нийтлэг журам батлах тухай”;
- Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Барилга хот байгуулалтын яамны сайдын хамтарсан 2015 оны “Журам батлах тухай” А-230/127 дугаар тушаал;
- НИТХ-ын 2016 оны “Улаанбаатар хотын усны эх үүсвэрийн хамгаалалтын бүсийг шинэчлэн тогтоох тухай” 50 дугаар тогтоол;
- МУШС, БОНХЯ-ны хамтарсан 18/А49 дугаар тушаал;
- МУЗГ-ын 2018 оны “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн лагийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 73 дугаар тогтоол
- НИТХ-ын 3 тогтоол, НЗД-ын 4 захирамж, ХСУХАТАҮЗХ-ны 4 тогтоол, ТАЗ-ийн 5 тогтоол зэрэг дээд газрын тогтол шийдвэрийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд тайлант онд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хот байгуулалтын тухай хууль / шинэчилсэн найруулга/
- Геодези, зураг зүйн тухай хууль /шинэчилсэн найруулга/
- Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай /шинэчилсэн найруулга/;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн өөрчлөлт;
- ЗГ-ын 2023 оны 49 дүгээр тогтоол “2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний

үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын “Үйл ажиллагааны хяналтын хэлтэс” нь байгууллагын дотоод хяналтыг зохион байгуулахдаа МУЗГ-ын 2011 оны “Нийтлэг журам батлах тухай” 311 дүгээр тогтоол, НЗД-ын 2023 оны А/727 дугаар захирамжаар баталсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам”, байгууллагын даргын 2023 оны А/283 дугаар тушаалаар батлагдсан “Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ыг баримтлан 149 ажил төлөвлөснөөс 96.5 хувийн биелэлттэй байна. Үүнээс санхүү, нягтлан бодох бүртгэл, хөрөнгөтэй холбоотой төлөвлөгөөт ба төлөвлөгөөт бус хяналт шалгалтын хүрээнд хөрөнгийн бүртгэл, сэлбэг материалын зарцуулалтын зардлын бүртгэлийн анхан шатны баримтын бүрдүүлэлт, агуулахын эмх цэгц, хөрөнгийн хаягжуулалт, агуулахад түүвэр тооллого хийх, ажилчдын байрны хуримтлагдсан төлбөр тооцоог барагдуулуулах, байгууллагын алдагдал бууруулах ажлын хэсэгт ажиллах, өмнөх онд өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хянах, санхүүгийн хяналтыг нэмэгдүүлэх зорилготой санхүү бүртгэл, тайлагналын үйл ажиллагаанд 53 удаагийн шалгалт хийж, зөвлөмж өгч ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ нь газрын даргын 2020 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн А/87 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөн ажиллаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааны бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,396,940.7 мянган төгрөгөөр буюу 0.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	44,714,477.6	59,363,021.1	14,648,543.5
Авлага	14,291,019.5	12,692,216.6	-1,598,802.8
Урьдчилгаа	316,962.7	294,162.5	-22,800.2

Бараа материал	9,204,602.2	15,061,291.4	5,856,689.2
Үндсэн хөрөнгө	424,867,700.7	402,587,130.3	-22,280,570.4
Нийт хөрөнгө	493,394,762.7	489,997,822.0	-3,396,940.7
Богино хугацаат өр төлбөр	3,354,059.2	1,777,532.0	-1,576,527.2
Урт хугацаат өр төлбөр	578,345.6	109,349.8	-468,995.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	489,462,357.9	488,110,940.2	-1,351,417.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	493,394,762.7	489,997,822.0	-3,396,940.7

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, засгийн газрын оролцоо данснууд байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл нь өмнөх оноос 14,648,543.5 мянган төгрөгөөр өссөн нь ХСУХАТАУЗЗ-ийн 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 96 дугаар тогтоолоор 1 м.куб усны дундаж тариф болон төлбөрт үйлчилгээний тариф тус тус нэмэгдсэн, иргэдийн нийслэл хотод ирэх шилжилт хөдөлгөөнөөс хамааран хэрэглээний цэвэр усны хэмжээ, бохир усны татан зайлуулах хэмжээ ихэссэнтэй холбоотой байна.

Дансны авлага нь 1,598,802.8 мянган төгрөгөөр буурсан нь айл өрх, албан байгууллагаас авах цэвэр, бохир усны төлбөр тооцооны дансны авлагыг барагдуулж, НӨАТ-ын авлага 170,102.0 мянга, ажилчдаас авах авлага 16,323.9 мянган төгрөгөөр тус тус буурснаас шалтгаалсан байна.

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл нь УБЦТС ХК-д цахилгааны илүү төлөлт 13,270.0 мянга, бэлтгэн нийлүүлэгчид төлөх урьдчилгаа 207,693.0 мянга, Налайхын замын болон Сэлбэ коллекторын ажлын барьцааны авлага 73,199.5 мянга, нийт 294,162.5 мянган төгрөгийн үлдэгдэл байгаа бөгөөд Байгаль орчны үнэлгээний ажил бүрэн хийгдэж дууссан байна.

Бараа материалын дансанд тайлант хугацаанд 25,108,985.4 мянган төгрөгийн худалдан авалт хийж, 19,252,296.2 мянган төгрөгийн зарцуулалт хийсэн байна.

Үндсэн хөрөнгийн данс нь тайлант онд өөрийн хөрөнгө оруулалтаар их засварын болон шугам доторлосон нийт 6,897,603.9 мянга, улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1,034,010.5 мянга, хандив тусламжаар 13,600.0 мянга, аудитын зөвлөмжөөр бараа материалын данснаас шилжүүлсэн 83,600.0 мянга, Бүгд Найрамдах Австри улс болон МУЗГ хооронд байгуулсан санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийн дагуу хөнгөлттэй зээлийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн шугам доторлогооны хөрөнгө 36,834.6 мянга, нийт 8,065,649.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, НӨХГ-ын даргын 2023.06.16-ны өдрийн А/165 дугаар тушаалаар 2,483,610.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хассан байна.

Биет бус хөрөнгө нь өөрийн хөрөнгөөр программын сайжруулалт 480,850.1 мянга, хандив буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 9,320.0 мянга, нийт 490,170.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, НӨХГ-ын шийдвэрээр хасагдсан 88,435.1 мянган төгрөгийн хөрөнгө байна.

Богино хугацаат өр төлбөрийн дансанд хөрөнгө оруулалтын барьцааны өглөг, хэмжүүр баталгаажуулалтын өглөг, хэрэглэгчдээс урьдчилж төлсөн усны мөнгө болон ААНОАТ, НӨАТ, ХХОАТ-ын өглөг байгаа бөгөөд материаллаг хэмжээгээр ААНОАТ-ын өглөг 1,692,860.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Урт хугацаат өр төлбөрийн данс нь 468,995.8 мянган төгрөгөөр буурсан нь 1 жилээс дээш хугацаатай хөрөнгө оруулалтын ажлуудыг барьцааны төлбөрөөс чөлөөлсөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өмнөх оноос 1,351,417.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүн ахмадын сангийн зарцуулалт, МУЗГ-ын 2023 оны 373 дугаар тогтоолын дагуу Дуусаагүй барилга данснаас хассан 343,656.7 мянга, НӨХГ-т төвлөрүүлсэн ноогдол ашиг зэргээс шалтгаалсан байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө /техник, эдийн засгийн үзүүлэлт,

зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, дээд шатны байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

НӨХГ-ын даргатай 2023 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 2023/02 дугаар бүхий “Ус сувгийн удирдах газар орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захиралтай байгуулах онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-г байгуулан, Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын 2023 оны үйлдвэрлэл, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагчаар батлуулан, ажилласан байна.

Тайлант оны нийт орлогыг 100,978,475.3 мянган төгрөгөөр, нийт зардлыг 120,775,905.3 мянган төгрөгөөр, алдагдлыг 18,579,670.1 мянган төгрөгөөр тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 10,416,370.0 мянган төгрөгийг төлөвлөсөн байна.

Орлогын эх үүсвэр нь цэвэр ус түгээх, бохир ус татан зайлуулах, цэвэр бохир усанд лабораторийн шинжилгээ хийх гэсэн үндсэн үйл ажиллагаанаас олсон орлого болон үйл ажиллагааны бус орлогоос бүрдэх бөгөөд тайлант хугацааны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг алдагдалтай баталсан нь төрөөс усны үнэ тарифыг тогтоодог бөгөөд ашгийн төлөө бус төрийн өмчийн байгууллагатай холбоотой юм.

Гүйцэтгэлээр 106,337,564.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 116,158,432.8 мянган төгрөгийн зардал гарган, 7,631,225.6 мянган төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Хүснэгт 2. 2023 оны эдийн засгийн үндсэн зорилт, зорилтот түвшин

/ мянган төгрөгөөр /

№	Үзүүлэлт	2022 оны гүйцэтгэл	2023 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт	*				
	Борлуулах ус	54,814.50	54,814.50	57,580.10	-2,765.60	105.1%
	Татан зайлуулах ус	43,177.80	43,157.90	45,530.40	-2,372.50	105.5%
2	Нийт орлого	102,999,703.20	100,978,475.30	106,337,564.70	-5,359,089.40	105.3%
	Үүнээс: Цэвэр борлуулалт	100,978,475.30	97,972,371.20	103,110,514.50	-5,138,143.30	105.2%
3	Нийт зардал	99,096,944.50	120,775,905.00	116,158,863.10	4,617,041.90	96.2%
	Үүнээс:				-	
	а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	92,671,194.70		108,981,088.40		
	б) Ерөнхий ба удирдлагын зардал	5,617,696.90		7,177,344.40		
	в) Хөрөнгө оруулалт их засвар	9,253,004.40	10,416,370.00	7,278,314.30	3,138,055.70	69.9%
4	Цэвэр ашиг, алдагдал	1,880,668.70	-18,579,670.10	-7,631,225.60	-10,948,444.50	41.1%

Нийт орлогын гүйцэтгэл 106,337,564.7 мянган төгрөг болж төлөвлөснөөс 5,359,089.4 мянган төгрөг буюу 5.3 хувиар давсан нь:

- Цэвэр усны хэрэглээ төлөвлөснөөс өссөн;
- Цэвэр усны хэрэглээний дундаж тариф, бохир усны үйлчилгээний дундаж тариф нэмэгдсэн;
- Бусад орлого төлөвлөснөөс давж биелсэн; зэргээс шалтгаалжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 116,158,432.8 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 4,617,472.5 мянган төгрөг буюу 96.2 хувиар гүйцэтгэлтэй байна. Энэ нь батлагдсан орон тооноос 78 орон тоо дутуу ажилласан, сургалтыг ихэвчлэн цахим орчинд зохион байгуулсан, бодисын нэг бүрийн дундаж үнэ төлөвлөснөөс багаар нийлүүлэгдсэн зэргээс шалтгаалан хлор, бодисын зардлыг их хэмжээгээр хэмнэсэн, сэлбэг хэрэгсэл, түлш шатахуун болон төслийн зардлуудыг хэмнэсэн зэрэг нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 140 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 7,278,314.3 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр алдагдал 7,631,225.6 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 10,948,444.5 мянган төгрөгөөр буурсан байгаа нь цэвэр, бохир усны тариф нэмэгдсэн, иргэд, ААНБ-ын усны хэрэглээ төлөвлөснөөс нэмэгдсэн, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд үйл ажиллагааны зардлыг хэмнэсэн зэрэг нөлөөлжээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахаар анхан шатны баримтын бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах, жилийн эцсийн тооллогын үр дүнг хэлэлцэн шийдвэрлэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, авлага өглөгийн үлдэгдлийг тайлант оны эцэст тооцоо нийлж, акт үйлдэх тухай зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг НТАГ-ын Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн ахлах аудитор Н.Бадамхатан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Отгонбаяр, хэлтсийн дарга Х.Түвшинбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Эрдэнэжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ нь 2023 оны санхүүгийн тайлангаа НТАГ-т 2024 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн 4/219 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2022 оны санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайланг, суурь үзүүлэлтээр борлуулсан бүтээгдэхүүний өртгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “бага” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн борлуулсан бүтээгдэхүүний өртгийн 92,671,195.0 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 1,853,423.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

Эдийн засаг, санхүүгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшний төлөвлөлтөөс орон тоо дутуу ажилласантай холбоотойгоор хоол, унааны хөнгөлөлтийн зардлыг 117,312.3 мянга, цахим сургалтыг явуулж, сургалтын зардлыг 86,843.6 мянга, нийгмийн арга хэмжээ зохион байгуулах, шагнал урамшууллын дагалдах мөнгөн олговрыг олгох зэргийг хэмнэснээр 17,549.0 мянга, сэлбэг хэрэгсэл, хлор, бодис, хангамжийн зардал 1,677,455.7 мянга, шинэ объектууд хугацаандаа ашиглалтад ороогүй, эрчим хүчний хэмнэлтийн шинэ технологи нэвтрүүлсэн, дотоод хэрэглээний усны зардлыг хэмнэснээр 1,230,609.2 мянга, “Алдагдлыг бууруулах” төлөвлөгөөний хүрээнд харуул хамгаалалтын зардал 195,288.0 мянга, урсгал засвар, аваарын нөөц, лаг, бичиг хэргийн зардал 694,740.5 мянга, харилцаа холбоо, томилолт, зар сурталчилгааны зардал 40,072.0 мянга, банкны үйлчилгээний зардал 2,088.2 мянга, хөдөлмөр хамгаалал, лаборатори, төслийн зардал 758,440.4 мянга, татвар хураамж, даатгалын зардал 80,673.7 мянга, хөрөнгө акталсантай холбоотойгоор элэгдлийн зардал 1,072,842.0 мянгаар тус тус дутуу зарцуулж, 4,617,472.5 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгосон.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 25 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих мэдээллийг бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

НҮА, УЦБА, ЦБА зэрэг алба хэлтсүүдийн ажилчдын цайны газар, амралтын газрын хүнсний гол хэрэглээ болох мах, хүнсний ногооны 101,068.6 мянган төгрөгийн худалдан авалтыг цахим дэлгүүрээс хийгээгүй, худалдан авах ажиллагааны хууль журмыг хэрэгжүүлээгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1. “Хуульд өөрөөр заагаагүй бол худалдан авах ажиллагааг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг цахим системээр гүйцэтгэнэ”; 30 дугаар зүйлийн 30.2.3. “ерөнхий гэрээ байгуулах, цахим дэлгүүрээс бараа, үйлчилгээ худалдан авах.” заалтуудыг хэрэгжүүлээгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хүнсний гол бүтээгдэхүүн болох мах, хүнсний ногоог Хангамжийн хэлтэс нь худалдан авах ажиллагааны хууль журмын дагуу зохион байгуулж, жилийн төсөвтөө багтаан худалдан авалтыг зохион байгуулах зөвлөмж өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар 8 зөвлөмж өгсөн. Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад 5 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 574,862.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлагыг, 807,489.2 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 10 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-

Албан шаардлага	4	574,862.9	1	343,656.7	59.8%
Зөвлөмж	10	807,489.2	9	807,489.2	90.0%
Нийт дүн	10	939,268.1	9	939,268.1	74.9%

Өмнөх оны аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад хөрөнгийн тооллого, газрын бүртгэл, нөөц тоног төхөөрөмжтэй холбоотой зөвлөмжүүдийг хэрэгжүүлээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагын Шугамаар ус хангах алба болон Зөөврийн ус хангах албаны Ус түгээгүүрийн байрнаас усны картаа урьдчилан цэнэглээд ус авдаг хэрэглэгчдийн урьдчилж орсон усны төлбөрийн карт дахь үлдэгдлийг баталгаажуулах боломжгүй тул албадын ахлах нягтлан бодогч нар нь орлогын мэргэжилтэнтэй зөвхөн санхүүгийн дансны үлдэгдлийн түвшинд 413,826.8 мянган төгрөгийг тооцоо нийлж баталгаажуулж байгаа нь хангалттай, зохистой нотолгоо болохгүй байна. Гэтэл тус байгууллага нь усны орлогын бүртгэл, үйл ажиллагааг хянах ХХХМС гэсэн программыг 2021-2022 онуудад шинээр авч хэрэглэж байгаа бөгөөд тайлант оны байдлаар тус программын нийт өртөг нь 249,138.3 мянган төгрөг байна. Иймд энэ өндөр өртөг бүхий программыг ашиглан усны картын үлдэгдлийг хэрэглэгчдээр эсвэл байршил, хэсэг бүрээр гаргаж, орлогын мэргэжилтэнтэй тооцоо нийлэн баталгаажуулж болох эсэхийг судлан хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд үүнийг дараагийн аудитаар анхааран үзэх болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 1,502,521.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг санхүүгийн тайлан, тодруулгад залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Залруулсан алдаа:

- Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайланг Шугамын ашиглалт засварын алба нь зөрүүтэй тайлагнаснаас нэгтгэл тайлангийн хуримтлагдсан элэгдлийн дүн 1,501,521.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасныг залруулсан.

Аудитаар нийт 957,289.0 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, нөхөн төлүүлэх 1,465.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, зөрчлийг арилгах 921,225.7 мянган төгрөгийн 7 албан шаардлага хүргүүлж, 34,598.3 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

1. Ажилтан, албан хаагчдад томилолтын мөнгө олгохдоо цалин хөлс дээр нь томилолтоор ажилласан хугацааны хоолны мөнгө 1,465.0 мянган төгрөгийг давхардуулан олгосон /хавсралтаар давхардсан тоогоор 42 ажилтанд/ нь МУЗГ-ын 2019 оны 06 дугаар тогтоол Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2 бүлгийн 2.7. "Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ: 2.2.1. "унааны зардал", 2.2.2. "байрны зардал", 2.2.3. "хоолны зардал"; Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйл: "Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 7.1.7 "хоол, унааны мөнгө"; заалтуудыг хэрэгжүүлээгүй.

5.2 Албан шаардлага

1. Тооллогын комиссын нарийн бичгийн даргаар хөрөнгө хариуцсан нягтлан бодогч, гишүүдэд хөрөнгийн бүртгэл, ашиглалт хариуцсан албадын ахлах болон тооцооны нябо нарыг оролцуулсан, тооллогын бүртгэл, тооцоо бодсон актыг хөтлөөгүй, албадын тооллогын комиссын илтгэх хуудсаарх дүн нь үндсэн хөрөнгийн тайлангаарх дүнгээс зөрүүтэй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1 "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч, ерөнхий нягтлан бодогч нь тооллого эхлэхийн өмнө дараах бэлтгэл хангасан байх үүрэгтэй", 71.1.1 "үндсэн хөрөнгөд гарсан хөдөлгөөн, өөрчлөлтийг нягтлан бодохын дэлгэрэнгүй бүртгэлд тусгасан байх, техник, технологийн баримт бичгийг гүйцэд бүрдүүлсэн байх", 71.1.2 "бараа, материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг цэгцлэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгасан байх", СС-ын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралт "Өмчийн бүх хэлбэрийн ААНБ-д нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар"-ын 8. "Эд хөрөнгийн тооллогын бүртгэлд байгууллагын нэр, эд хөрөнгийн нэр төрөл, хаана ашиглагдаж байгаа, хөрөнгийн чанар байдал зэргийг тэмдэглэхийн хамт тооллогын бүртгэлийн хуудас бүрийн ард тооллогын комиссын дарга, гишүүд, эд хариуцагч гарын үсэг зурна"; заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

2. Байгууллагын хэмжээн дэх нийт газрын бүртгэлийг тулгахад 9 газрын хэмжээ 724 м.кв буюу 66,573.5 мянган төгрөгийн илүү дүнгээр нягтлан бодох бүртгэлд тусгагдсан /хавсралтаар/ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4. "үнэн зөв байх", 5.1.5. "хэмжигдэхүйц байх", 13 дугаар зүйлийн 13.1. "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно". заалтуудыг хэрэгжүүлээгүй.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3. Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй 31,063.0 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэгдсэн зөрчлийг арилгаагүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй нь Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын хавсралт 1 "Аж ахуй нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгын бэлтгэх заавар"-ын 1.Үндсэн хөрөнгө "Нэгээс дээш тайлант хугацаанд үйлдвэрлэл, борлуулалт, үйлчилгээ, бусдад түрээслүүлэх эсхүл захиргааны зориулалтаар ашиглаж байгаа биет хөрөнгө үндсэн хөрөнгөнд хамаарна"; заалтыг хэрэгжүүлээгүй.

4. Агуулахад бүртгэлтэй ашиглагдахгүй, нөөцөд байгаа нийт 1,074,916.5 мянган төгрөгийн 1303 ширхэг тоног төхөөрөмжийн 32 хувь нь 2020 оноос өмнө авсан 3-аас дээш жил болсон ашиглалтын шаардлага хангах эсэх нь эргэлзээтэй 340,163.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмжүүд байгаа нь /хавсралтаар/ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6. "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх"; заалтыг хэрэгжүүлээгүй.

5. Санхүүгийн тайлангаарх дансны авлага, өглөг, БХӨТ, УХӨТ-ийн тооцоо нийлсэн актыг тулган баталгаажуулахад бүрэн тооцоо нийлж баталгаажуулаагүй 172,026.7 мянган төгрөгийн үлдэгдэл байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалтыг хэрэгжүүлээгүй.

6. Нийт 26,000.0 мянган төгрөгийн видео шторк, вирусн программыг шууд зардлаар тайлагнасан, өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1. "Нягтлан бодогч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөж ажиллана", Зар сурталчилгааны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1."Зар сурталчилгаа захиалагч, бүтээгч, түгээгч зар сурталчилгаатай холбоотой баримт болон тэдгээрийн хуулбарыг тухайн зар сурталчилгааг сүүлчийн удаа түгээснээс хойш 6 сараас доошгүй хугацаагаар хадгална." заалтуудыг хэрэгжүүлээгүй.

7. БХУСАТ-ны данс бүртгэлд нийт 285,399.4 мянган төгрөгийн үнэ бүхий 28.9-63.10 м.кв талбайтай, 12 айлын орон сууц бүртгэлтэй байгаа боловч эдгээр байруудын гэрчилгээ байхгүй, хувь хүмүүсийн нэр дээр өмчлөлтэй болсон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4. "үнэн зөв байх"; 5.1.5. "хэмжигдэхүйц байх"; 13 дугаар зүйлийн 13.1. "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" заалтуудыг хэрэгжүүлээгүй.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт-1: ЖМС-гаас мөнгө зарцуулахдаа 4,263.0 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулаагүй (УХА-цайны өрөөг засварлахад-430.5 мянга, ЗУХА-бичгийн цаас авах, хор цэнэглэх, карт авах, складны тавиур хийх-2.603.0 мянга, МТАН-тохижилтын зардалд 634.7 мянга, УЦБА-албаны агуулах тохижуулах, няравын складанд засвар хийх-594.8 мянга) нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 "жинхэнэ хэрэгжилтийн"; 5.1.4 "үнэн зөв байх"; УСУГ-ын даргын 2016 оны А/151 дугаар тушаалын хавсралт "Байгууллагын жижиг мөнгөн сангийн ажиллагааны журам"-ын 2.3 "Ажилтан нь байгууллагын сэлбэг хэрэгсэл, бараа материалын захиалгын нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан зүйлийг авахдаа..., даргаар баталгаажуулан худалдан авах эрхийг олгоно"; заалтуудыг зөрчсөн.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын жижиг мөнгөн сангийн журмыг мөрдөж ажиллах;

3. Илрүүлэлт-3: Байгууллагын болон НЗД-ын нэрэмжит нутгийн захиргааны тэмцээн, 35-аас дээш насныхны спортын тэмцээн гэх мэт спортын арга хэмжээнд 19,233.9 мянга, урлагийн бага наадамд 4,420.8 мянга, төслийн нээлтийн цайны зардалд 2,323.3 мянга, нийт

28,890.1 мянган төгрөгийг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3. "үр ашигтай байх"; 4.2.3. "хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх"; заалтуудыг зөрчсөн.

Өгсөн зөвлөмж: Үр ашиггүй, илүү зардлыг багасгах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах;

Илрүүлэлт-4: Цалингийн нэмэгдэл болон тооцоолол, цалингаас суутгасан суутгалыг давтан шалгахад ажилчдын цалингаас суутгасан суутгалыг танилцуулсан гарын үсэггүй, сахилгын шийтгэлийг давхардуулан 1,445.2 мянган төгрөгийг авсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4. "үнэн зөв байх"; 5.1.5. "хэмжигдэхүйц байх"; 13 дугаар зүйлийн 13.1. "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно"; заалтуудыг зөрчсөн.

Өгсөн зөвлөмж: Цалингаас шууд суутгаж байгаа аливаа суутгалд гарын үсэг зуруулж, баталгаажуулах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн болон бусад холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тооллогын комиссын нарийн бичгээр хөрөнгийн нягтлан бодогчийг оруулсан, тооллогын бүртгэл, тооцоо бодсон баримтыг хавсаргаагүй	1	-			1	-						
Томилолтоор ажилласан ажилтнуудад хоолны мөнгийг давхардуулан өгсөн	1	1,465.0	1	1,465.0								
Газрын хэмжээ нь нягтлан бодох бүртгэлд зөрүүтэй тусгагдсан.	1	66,573.5			1	66,573.5						
Бараа материалын шинжтэй хөрөнгийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн	1	31,063.0			1	31,063.0						
Агуулахад 3-аас дээш жил болсон тоног төхөөрөмжүүд байна	1	340,163.1			1	340,163.2						
Санхүүгийн тайлангаар өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.	1	172,026.7			1	172,026.7						
ЖМС-г зориулалтын дагуу ашиглаагүй.	1	4,263.0					1	4,263.0				
Видео шторк, вирусын программыг шууд зардлаар бүртгэсэн	1	26,000.0			1	26,000.0						
Спортын тэмцээн, урлагийн наадмыг олон удаа зохиож, үргүй зардал гаргасан.	1	28,890.1					1	28,890.1				
Хувь хүнд өмчлөгдсөн 12 орон сууц бүртгэлтэй байна	1	285,399.4			1	285,399.4						
Цалингаас гарын үсэггүй суутгалыг авсан байна	1	1,445.2					1	1,445.2				
Дүн	11	957,289.0	1	1,465.0	7	921,225.7	3	34,598.3				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
НҮА, УЦБА, ЦБА зэрэг алба хэлтсүүдийн ажилчдын цайны газар, амралтын газрын хүнсний гол хэрэглээ болох мах, хүнсний ногоог цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, худалдан авах ажиллагааны хууль журмыг хэрэгжүүлээгүй байна.	1	101,068.6					1	101,068.6
Дүн	1	101,068.6	-	-	-	-	1	101,068.6